



НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА Х.НЯМБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.30 № 03/10895

танай _____-ны № _____-т

Хуулийн хэрэгжилт хангуулах тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг 2014 оны 09 дүгээр сарын 17-ноос 2014 оны 9 дүгээр сарын 24-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцлаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцахад илэрсэн зөрчил, дутагдалд дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор төлөөлөгч нарт улирлын урамшуулал олгохдоо Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан “Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд урамшуулал олгох журам-ыг мөрдөж ажиллах;

Тодруулбал, ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оролцсон байдал, хороо, дэд хороо, ажлын хэсэг болон түр хороонд ажилласан байдал, сонгогдсон тойрогтоо ажилласан байдал, тогтоол, шийдвэрийг олон нийтэд сурталчилсан байдал зэрэг шалгуурыг хангасан эсэхийг үнэлсний үндсэн дээр урамшуулал олгодог байтал төлөөлөгч нарын ажлын гүйцэтгэл гараагүй байхад урамшуулал олгосон;

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод журамд “Төрийн албанд тогтвор суурьшилтай /1-ээс дээш жил/ ажиллаж, өөрийн гэсэн орон сууцгүй байгаа ажлын албаны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, гэр бүлийг дэмжихэд зориулан жилд нэг удаа 5 000 000 /таван сая/-аас 10 000 000 /арван сая/ хүртэлх төгрөгийн буцалтгүй тусламж олгож болох”-оор тусгасан байгаа боловч ямар шалгуур үзүүлэлтээр буцалтгүй тусламжийн мөнгөний хэмжээг ялгамжтай олгох нь тодорхойгүй байх тул журмын заалтыг ойлгомжтой болгон, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

022832

3. Давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэмжээнд гаргаж, нээлттэй болгох;


4. Төсвийн хөрөнгийг үр дүнтэй, зориулалтын дагуу зарцуулдаг байх, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

5. 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/94 дугаартай тогтоолоор Ардын хувьсгалын 93 жилийн ойн арга хэмжээнд 4.066.500 төгрөг, төрийн удирдах албан тушаалтнууд, бүх шатны ИТХ-ын төлөөлөгч болон иргэдэд хүндэтгэл үзүүлэх зорилгоор хорхог хийхэд 720.000 төгрөг, ууц 800000 төгрөг, айраг 1.200.000 төгрөг, цэвэр ус 400.000 төгрөг гэх мэтээр зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 6-д “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчсөн;

6. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны А/85 дугаартай тогтоолоор төлөөлөгч О.Ганбаатарт 3.000.000 төгрөг, 2013 оны А/98 дугаартай тогтоолоор төлөөлөгч Б.Мөнхцэцэгт 5.000.000 төгрөг, 2013 оны А/109 дугаартай тогтоолоор төлөөлөгч Д.Ундармаад 5.000.000 төгрөг, 2014 оны А/112 дугаартай тогтоолоор төлөөлөгч Т.Төрмөнхөд 10.000.000 төгрөгийг тус тус ар гэрийн аргагүй байдлыг харгалзан буцалтгүй тусламж болгон олгосон, 2013 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/19 дугаартай тогтоолоор Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан нэг хүнд 200.000 төгрөг буюу нийт 43 хүнд 8.600.000 төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламж хэлбэрээр олгохдоо Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.13 дахь “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг үндэслэл болгосныг хуулийн зохих заалтад нийцүүлэх арга хэмжээ авах зэрэг болно.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан тушаалтнуудыг хамруулсан тодорхой арга хэмжээг зохион байгуулж дүнг 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

C:\DOCUMENTS\ALBANBICHIG\A4